



## ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн 2022 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг Засгийн газрын 2020 оны Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу үнэлгээг хийж эдийн засаг, нийгмийн гол үзүүлэлтийн хүрсэн үр дүн, дутагдал, төлөвлөлтийн уялдаа, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

### ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2020 оны Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6.2, 7.1 дэх заалт хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зарчмын дагуу эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийг үнэлж дүгнэв.

### МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, АНГИЛАХ, НЭГТГЭХ


Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг холбогдох хэлтэс, агентлагуудаас мэдээллийг авч, ҮСХорооны [www.1212.mn](http://www.1212.mn) цахим хуудсанд байрших албан ёсны статистик мэдээ, холбогдох байгууллагуудын мэдээлэлтэй уялдуулан нягталж, нэгтгэн гаргав.

### ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙН ДҮНГ ҮНЭЛЭХ

Аймгийн жилийн үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлт болох эдийн засгийн хөгжлийн 21 үзүүлэлт 81,2 хувь, нийгмийн 24 үзүүлэлт 87,9 хувь, нийт дүнгээр **84,5** хувийн гүйцэтгэлтэй байна.



Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн үр дүнг 2021 оны үнэлгээтэй харьцуулахад эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт 10,0 хувиар буурсан, нийгмийн хөгжлийн үзүүлэлт 13,2 хувиар өссөн, нийт дүнгээрээ 2022 онд 1,6 хувиар өссөн дүнтэй байна.





## БИЕЛЭЛТИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн биелэлтийн үр нөлөөг авч үзэхэд нийт 45 шалгуур үзүүлэлтийн 55,5 хувь нь үр дүнтэй, 28,8 хувь нь тодорхой үр дүнд хүрч, 6,6 хувь нь үр дүнд хүрээгүй байна.

Үр дүнд хүрээгүй үзүүлэлтийн шалтгааныг авч үзвэл:



2021 онд эдийн засаг, нийгмийн хөгжлийн үр дүнд хүрээгүй үзүүлэлтүүд гадаад хүчин зүйлээс буюу цар тахлын шалтгаалсан байсан ба энэхүү гадаад хүчин зүйлийн нөлөөлөл нь 2022 онд ч мөн адил нөлөөлсөн хэвээр байна. Учир нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагын тоо буурсан, хэрэглээний үнийн индекс өссөн, ажилгүйдлийн түвшин өссөн зэрэг үзүүлэлтийн хувь буурсан хэвээр байна.

Энэ жилийн тухайд байгалийн хүчин зүйлээс шалтгаалан малын тоо, хадлан, тэжээл бэлтгэлт, ургац хураалт зэрэг үзүүлэлтүүд буурсан байна.

### Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийн хүрээнд:

2022 оны дотоодын нийт бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ статистик мэдээгээр 2023 оны 6 сард гарах учир 2021 оны дотоодын нийт бүтээгдэхүүний тоо, хэмжээгээр үзүүлэлтийг тооцлоо.

2022 онд тусгай зориулалтын байгууллагуудын төсөв, орон нутгийн төсвөөс гарсан тул төсвийн тэнцэлд өөрчлөлт орсон байна.

Жижиг дунд үйлдвэрийн зээлийн эргэн төлөлтийн хувь өмнөх оноос буурсан хэдий ч 2020, 2021 онд ЖДҮ-ийн зээлээс авсан 15 аж ахуйн нэгж байгууллага,



иргэдийн зээлийн эргэн төлөлт 84,0 хувьтай байна. 2022 онд ЖДҮ-ийн зээл олгогдоогүй байна.

Хэрэглээний үнийн индекс өмнөх оноос өссөн нь бензиний үнэ нэмэгдсэн, өргөн хэрэглээний бараа материалын үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор өссөн байна.

Малын тоо 2021 оноос буурч байгаа нь малчид газрын гарц муу, өвөлжилт хүндрэх эрсдэлтэй байсан тул зах зээлд борлуулалт их хийсэн байна.

Мөн үр тариа, хадлан тэжээл, хүнсний ногооны ургац өмнөх оноос буурсан нь байгаль цаг ууртай холбоотойгоор газрын гарц муу, хур бороо ороогүйгээс шалтгаалсан байна.

### **Нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хүрээнд:**

PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж 50 байхад хэвийн гэж тооцдог бөгөөд Завхан аймагт 39 байгаа жилийн дунджаас бага байна.

Артерийн даралтын ихсэх өвчний эрт илрүүлэг, чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтыг 2022 оноос өмнөх жилүүдэд зорилтот бүлэгт чиглэн хамруулж хамрагдалтыг хувь өндөр байдаг байсан. 2022 оноос Эрүүл мэндийн сайдын тушаалаар 18 наснаас дээш насны иргэдийг хамруулдаг болсонтой холбоотой хамрагдалтын хувь бага харагдаж байна.

Хамран сургалтын хувийг гаргахдаа 2021 оны хүн амын тоог нас ахиулж бодож хувийг гаргасан байна. 2022 оны хүн амын тоо эцэслэн гаргахаар хамран сургалтын хувь дахин бодогдоно.

## **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ**

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах талаар хэлтэс, агентлагуудад зөвлөмж хүргүүлээ.

Цаг хугацааны хувьд тухайн оны статистик мэдээгээр дараа оны 1, 2 дугаар улиралд гардаг мэдээлэл байдаг тул хяналт-шинжилгээ, үнэлгээг өмнөх оны үзүүлэлтээр хэрэгжилтийг тооцож ажилласан.

Завхан аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт өмнөх оноос буурсан байгаа нь улсын эдийн засаг хямралтай, инфляцын түвшин өссөн зэрэгтэй холбоотой юм.



**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН                      А.МӨНХЦЭЦЭГ

**ХЯНАСАН:**

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА    Г.МЯГМАРСҮРЭН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА                              Н.БЯМБАДОРЖ

